



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

ОХУ-тай хийж буй гадаад худалдааны зарим асуудлаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай “Зөвлөлдөх уулзалт” зохион байгууллаа

Монгол Улсаас ОХУ-тай хийж буй гадаад худалдааг сүүлийн 10 жилийн дунджаар авч үзэхэд нийт гадаад худалдааны эргэлтийн 20 хувийг эзэлж байна. Тухайлбал, нийт экспортын ердөө гурван хувь, нийт импортын 33 хувь нь ОХУ-д ноогдож байна. Үүний улмаас ОХУ-тай хийж буй гадаад худалдаа алдагдалтай байдаг. Манай орны нефтийн бүтээгдэхүүний импортын эрэлт, хэрэгцээ, дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлттэй уялдан энэхүү алдагдлын хэмжээ цаашид хурдацтай өсөх хандлагатай байгаа. Иймд ОХУ-тай хийж буй гадаад худалдааг тэнцвэржүүлэх, ОХУ руу хийж буй экспортыг нэмэгдүүлэх, төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах арга замуудыг эрэлхийлэх шаардлага гарч байна.

Энэхүү шаардлагыг хангах хүрээнд Монголбанкны санаачилгаар “Зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулж, уг уулзалтад Сангийн яам, Гадаад хэргийн яам, Зам тээвэр барилга хот байгуулалтын яам, Эрдэс баялаг эрчим хүчний яам, Газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар төмөр зам зэрэг төрийн холбогдох байгууллага, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын зөвлөхүүд, ОХУ-тай гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн төлөөллүүд оролцлоо.

Уг уулзалтаар (i) Монгол Улс, ОХУ хоорондын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашдын хандлага, (ii) ОХУ-ын рублийн гадаад төлбөр тооцоо, валютын арилжаанд хэрэглэгдэж байгаа байдал болон (iii) ОХУ-тай хийхээр төлөвлөж буй своп хэлцлийн ерөнхий мэдээллийг тус тус танилцуулж, оролцогчидтай гадаад худалдааны алдагдлыг бууруулах, импортын төлбөр тооцоог эрсдэл багатай, уян хатан гүйцэтгэх, нефтийн бүтээгдэхүүний импортын төлбөрийг рублиэр төлөх боломж, Монголбанкнаас санал болгож буй одоогийн хувилбарын талаар чөлөөтэй ярилцаж, санал бодлоо нээлттэй солилцлоо.

Зөвлөлдөх уулзалтын үеэр гарсан санал, хүсэлтийг Монголбанкнаас төрийн бодлогод тусгуулахаар холбогдох байгууллагад уламжлах, төгрөг-рублийн своп хэлцлийн талаарх бодлогын саналдаа тусгахаар шийдвэрлэв.

МОНГОЛБАНК